

**СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМНЫ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

| Д/д | Яам-ны ГТ-д туссан | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв /сая.төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хэрэгжилт | Хугацаа | Хэрэгжилтийн хувь |
|---|--------------------|--|---------------------------------|--|-----------------------------------|--|--|---------------|-------------------|
| НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ | | | | | | | | | |
| Зорилт 1. Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогын хүрээнд "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл I"-ийг Хөвсгөл, Хэнтий аймагт хэрэгжүүлж, орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжийн орлогыг нэмэгдүүлнэ. | | | | | | | | | |
| 1 | 1.1 | "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл I"-ийг Хөвсгөл, Хэнтий аймагт хэрэгжүүлэх | 15,000.0 АХБ хөнгөлөл ттэй зээл | Төслийн хэрэгжилт 80 хувьд хүрсэн эсэх | Төслийн хэрэгжилт 50 хувьд хүрсэн | Төсөл I-ийн хэрэгжилт 80 хувьд хүрсэн байна. | <p>Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл-1"-ийг 2019 оноос эхлэн хэрэгжүүлж байгаа бөгөөд 2024 онд төслийн нэгжтэй хамтран батлагдсан төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.</p> <p>Үүнд:</p> <p>Хөвсгөл аймагт</p> <ol style="list-style-type: none"> Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газарт байгуулж буй 37.9 км авто зам, 7 зогсоолын гэрээт ажлын нийт хэрэгжилт 50% гүйцэтгэлтэй байна. Хатгал-Хүзүүвчийн шил чиглэлийн 5.5 км замын хажуугийн хөвөө дүүргэх, тэгшлэх, замын тэмдэг тэмдэглэгээ байрлуулах ажлууд хийгдэж байна. Хатгал-Жанхайн даваа-Тойлогт чиглэлийн 30.4 км замын трасс дагуу буталсан чулуун суурь дэвсэх, давуулах далангийн бетон хучилт, түүний тулц бэхэлгээ бетон цутгах, хуучин 2 төмөрбетон дөрвөлжин хоолойг сунгах ажлууд хийгдсэн. "ЧХАЖЦ-ын Мэдээллийн төв, цэвэрлэх байгууламжийн зураг төсөл, барилга угсралт, бараа нийлүүлэлт"-ийн гэрээт ажлын нийт хэрэгжилт 18%-н гүйцэтгэлтэй, барилга угсралтын ажил 28% гүйцэтгэлтэй, барилгын суuriйн каркас угсралт, бетон цутгалтын ажлууд хийгдсэн. Хөвсгөлийн Улсын Тусгай Хамгаалалттай Газар (ХУТХГ)-ын Хамгаалалтын захираганы оффис/жуулчны мэдээллийн төвийн барилга, төлбөр авах цэг, нийтийн ариун цэврийн байгууламжуудын барилга угсралтын ажил гүйцэтгэчийн тендер | III-IV улирал | 100% |

| | | | | | | |
|--|--|--|--|--|--|--|
| | | | | | <p>сонгон шалгаруулалтыг дуусгаж, гэрээлэн, ажлыг эхлүүлсэн. Хамгаалалтын захиргааны оффис/жуулчны мэдээллийн төвийн барилга угсралтын ажил 15%-н гүйцэтгэлтэй, барилгын суурь, гадна цахилгаан, холбоо, гүний худгийн байгууламжуудыг хийж гүйцэтгэгдсэн.</p> <p>6. Хөвсгөл аймгийн Мөрөн хотын төвийн нийтийн ариун цэврийн байгууламжийн барилга угсралтын ажил 15%, Алаг-Эрдэнэ сумын Жанхайн давааны нийтийн ариун цэврийн байгууламжийн барилга угсралтын ажил 15%-н гүйцэтгэлтэй байна.</p> <p>7. Хөвсгөл аймгийн Ханх суман дахь хатуу хог хаягдлын ландфилл болон бохир ус цэвэрлэх байгууламжуудын барилга угсралтын ажлуудыг дуусгаж, улсын комисс ажиллуулж, байнгын ашиглалтад оруулсан.</p> <p>8. Хөвсгөл аймагт хэрэгжүүлэх олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны нийт 4-н багц гэрээт ажлын хүрээнд "Жанхайн давааны худалдааны төв" байгуулах ажлууд дээр явган зам талбай, тохижилт болон гадна дотор цахилгаан хангамж, гэрэлтүүлгийн материал татан авалтууд хийж, хяналтын камерууд нийлүүлсэн бөгөөд 14.7%-н гүйцэтгэлтэй хэрэгжүүлэв.</p> <p>Хэнтий аймагт</p> <ol style="list-style-type: none"> 1. Хэнтий аймгийн Дадал суманд байгуулсан Хатуу хог хаягдлын ландфилл байгууламж дээр Улсын комисс ажиллуулсны дагуу орон нутагт хүлээлгэн өгч, байнгын ашиглалтад оруулсан. 2. Хэнтий аймаг дахь "Түүхэн аялал жуулчлалын цогцолборуудын аяллын маршрут, бүтээгдэхүүн, үйлчилгээг Google платформд оруулах" зөвлөх үйлчилгээний тендерийн баримт бичгийг боловсруулж дуусган, зарлаж, сонгон шалгаруулалтыг эхлүүлсэн. 3. Дадал сумын төвөөс "Чингис хаан" аялал жуулчлалын цогцолбор (ЧХАЖЦ) хүртэлх 1.9 км авто зам, зогсоолын барилга угсралтын ажлын тендерийн баримт бичгийг боловсруулж дуусган, зарлаж, сонгон шалгаруулалтыг эхлүүлсэн. 4. "Нутгийн оршин суугчдад түшиглэсэн хүртээмжтэй аялал жуулчлалын төлөвлөлт болон чадавхыг сайжруулах" төслийн Зорилт-1 болон "Тусгай хамгаалалттай газрын менежментийг боловсронгуй | |
|--|--|--|--|--|--|--|

| | | | | | | | |
|--|--|--|--|--|--|---|--|
| | | | | | | <p>боловсруулж, Зорилт-4-ийн хүрээнд "Эко аялал жуулчлалын төлөвлөлтийн зөвлөх үйлчилгээ"-ний гэрээт ажлыг хэрэгжүүлж дуусгав. Тус зөвлөх үйлчилгээний хүрээнд 4-н жилийн хугацаанд орон нутгийг аялал жуулчлал, хог хаягдлын чиглэлээр чадавхжуулах, байгалийн цогцолборт газрын менежментийг боловсронгуй болгох, бодлогын баримт бичгүүд боловсруулах, судалгаа хийх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэв. Нийт 2500 орчим хүнийг сургаж, 3000 орчим хүний мэдлэг ойлголтыг нэмэгдүүлснээр 2024 оны 12-р сарын байдлаар төслийн Зорилт-1 94%, Зорилт-4 68%-тай хэрэгжив.</p> <p>5. Төслийн хүрээнд нийт 3-н хатуу хог хаягдлын ландфилл байгууламж, 2 бохир ус цэвэрлэх байгууламж байгуулж, нийт 11-н ш машин, тоног төхөөрөмж нийлүүлж, 3-н хуучин хогийн цэгт техникийн нөхөн сэргээлт хийснээр "Хог хаягдлын менежментийг сайжруулах", төслийн Зорилт-3-ын хэрэгжилт 2024 оны 12-р сарын байдлаар 97%-тай хэрэгжив.</p> <p><u>2024 оны 12-р сарын байдлаар төслийн зорилтуудын хэрэгжилтийн хувь:</u></p> <ul style="list-style-type: none"> Зорилт-1: 94% Зорилт-2: 48.2% Зорилт-3: 97% Зорилт-4: 68% <p>Улсын Их Хурлын 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн чуулганаар Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбоотойгоор Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын Сайдын чиг үүрэгт аялал жуулчлалын бодлогын асуудал шилжсэн тул ТАЖХТ-ийн хэрэгжүүлэх чиг үүргийг шилжүүлэн авах тухай 1/702 тоот албан тоотыг Сангийн яамруу илгээсэн. Үүнтэй холбоотой шилжих ажил хийгдэж байна.</p> | |
|--|--|--|--|--|--|---|--|

Зорилт 2. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшшуулэн, иргэд, жуулчдын тоог нэг саяд хүргэнэ. /ЗГУАХХАХТ 3.4.2/

| | | | | | | | | | |
|---|-----|--|---|------------------------------|--|--|---|---------------|-----|
| 2 | 2.1 | Зочлох үйлчилгээний 4-5 стандартыг боловсруулж, холбогдох байгууллагад хургуулсан байна. | - | 4-5 стандарт хургуулсан эсэх | Зочлох үйлчилгээний стандартын жишигт нийцүүлэн төслийг боловсруулсан. | Зочлох үйлчилгээний 4-5 стандартыг боловсруулж, холбогдох байгууллагад | <p>- MNS 4588:2008 Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ-Зочид буудалд тавих өрөнхий шаардлагын стандартыг олон улсын стандарттай харьцуулан шинэчлэхээр зочид буудлуудын төлөөлөл бүхий 18 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, 4 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж стандартын шинэчилсэн төслийг боловсруулсан.</p> | III-IV улирал | 90% |
|---|-----|--|---|------------------------------|--|--|---|---------------|-----|

| | | | | | | | |
|--|--|--|--|--|-------------------|--|--|
| | | | | | хүргүүлсэн байна. | <ul style="list-style-type: none"> - MNS 5927:2008 Зочид буудлын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлагын стандартын төслийг 247 шалгуур үзүүлэлттэй байхаар боловсруулсан. - MNS 6043:2019 Амралтын газар, жуулчны баазад тавих өрөнхий шаардлагын стандартын төслийг хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бутэц, ерөө үйлчилгээ, утгах үйлчилгээ, хүний нөөцийн гэсэн чиглэлүүдээр баг бий болгон 3 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулахаас гадна дэн буудал, гэр буудал, жуулчны бааз, амралтын газрын үйл ажиллагаа эрхэлдэг ААНБ-ын төлөөллийг хамруулж ажилласан. - MNS 5738:2007 Аялал жуулчлал. Дэн буудал. Ерөнхий шаардлагын стандартыг 15 зүйл, 126 шалгуур үзүүлэлттэй байхаар боловсруулж, 4 удаа хэлэлцүүлсэн. <p>БОАЖЯ, ТоС хөтөлбөртэй хамтран хэрэгжкуулж буй "Ногоон аялал жуулчлал" хөтөлбөрийн хүрээнд танилцуулж, байгальд ээлтэй, үйлчилгээг жуулчдад хүргэх зөвлөмж боловсруулсан.</p> <p>2024 оны 12 дугаар сарын 09-ны өдөр сүүлийн хэлэлцүүлгийг зохион байгуулж Стандарт хэмжил зүйн газарт хүргүүлээд байна.</p> | |
|--|--|--|--|--|-------------------|--|--|

Зорилт 3. Монголын нүүдлийн соёлын онцлогт тохирсон үндэсний шинэлэг, сор бутээл, брэнд бутээгдэхүүн үйлдвэрлэж, аялал жуулчлалыг дэмжинэ. / ЗГУАХХАХТ 3.4.5/

| | | | | | | | | | |
|---|-----|--|--------------|--|--|--|---|---------------|------|
| 3 | 3.1 | Байгаль, түүх, соёлын аялал жуулчлалын эвент арга хэмжээг зохион байгуулж, цар хүрээг өргөжүүлэх | 900,0 АЖХ | Календарийн дагуу зохион байгуулсан эвент арга хэмжээний тоо | 2023 оны календарийн дагуу 69 эвент зохион байгуулагдаж, аялал жуулчлалын 20 гаруй арга хэмжээг мэргжил санхүүгийн хувьд дэмжин хамтран ажилласан. | 20-аас дээш эвент арга хэмжээ зохион байгуулж хамтран ажилласан байна. | <p>Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн хуралдаанаар батлуулсан 2024 оны эвентийн календарийн дагуу арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласан.</p> <p>Үндэсний бахархал, Монгол өв соёлыг өвлүүлэх, үндэсний дархлаа бий болгох аялал жуулчлалын шинэ бутээгдэхүүн бий болгох зорилтын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - Архангай аймагт "АРА фестиваль", "Улаанбаатар олон улсын медиа урлагийн наадам", "Нүүдэлчин дэлхийн фестиваль", "Бүргэдийн баяр", "Бодибилдингийн фитнесийн ази тивийн аварга шалгаруулах тэмцээн", "Агтаны хүрээт хүлэгч эрсийн наадам", "Хар хорин айс фестиваль" зэргийг дэмжин хамтран ажилласан. - Үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд сур харвааны ажлын хэсэгтт ажиллахаас гадна жуулчдад зориулан наадмын нээлтийн арга хэмжээг орой тоглуулах арга хэмжээг зохион байгуулсан. | III-IV улирал | 100% |
|---|-----|--|--------------|--|--|--|---|---------------|------|

| | | | | | | | | | |
|---|-----|---|---|------------------------------------|--|---|---|---------------|------|
| | | | | | | - Монголын здийн засгийн форумын ажлын хэсэгт орж "Аялал жуулчлалын салбар хуралдаан"-ы зохион байгуулалтыг хариуцан ажилласан. | | | |
| 4 | 3.2 | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын 2025 оны календарь гарган батлуулах МУТЖҮЧ – 8.2.1, ССАЖЗЯГТ – 2.6.5 | - | Календарь батлагдсан эсэх | 2024 оны календарь | Календарийг батлуулсан байна. | Үндэсний хэмжээний аялал жуулчлалын нэгдсэн календарийг батлуулахаар 21 аймаг, нийслэл, төрийн байгууллагуудаас 2025 онд зохион байгуулах эвентийн саналыг хүлээн авч, Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хорооны 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар "2025 оны эвентийн календарь"-ийн төслийг танилцуулсан. | III-IV улирал | 100% |
| 5 | 3.3 | "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивалийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх СТХ 8.5, ССАЖЗЯГТ 2.4.5 | - | Фестивалийг зохион байгуулсан эсэх | Зохион байгуулдаг арга хэмжээ тогтмолжсон. | Фестивалийг зохион байгуулж, 100,000-аас доошгүй хүнийг хамруулан, сурталчилсан байна. | <p>"Нүүдэлчин" дэлхийн соёлын фестиваль нь дотоодын төдийгүй гадаадын жуулчдын сэтгэлийг татсан эвент болон хөгжкийг байгаа бөгөөд 2024 оны 08 дугаар сарын 16-аас 18-ны өдрүүдэд Налайх дүүргийн Тайж хайрханы бэлд зохион байгуулагдсан.</p> <p>АУБХЗГ-ын зүгээс тус арга хэмжээг Монгол Улсыг дэлхийд төлөөлөх соёл, аялал жуулчлалын эвент гэж үзэн дараах үйл ажиллагаагаар дэмжин хамтран ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Арга хэмжээний зохион байгуулалтын ажлын хэсэгт ажиллаж аялал жуулчлалын салбарын 50 гаруй хүндэт зочдын жагсаалтыг гарган, урьж оролцуулах, хүлээн авч уулзах ажлыг зохион байгуулсан. - Гадаадын жуулчдад мэдээлэл хүргэх, сурталчлах зорилгоор Чингис хаан олон улсын нисэх буудлын 6 ургалаас зорчигч орж ирэх уулзвар дээр нүүдэлчин фестивалийн постерыг байршуулж өдөрт ойролцоогоор 3000 зорчигчдод мэдээлэл хүргэгдсэн байна. - Тус фестивальд оролцохоор хүрэлцэн ирсэн гадаадын хүндэт зочдыг байршуулахад дэмжлэг үзүүлж зочид буудал, жуулчны баазуудыг тодорхойлж хөнгөлөлт үзүүлж хамтран ажилласан. - Арга хэмжээний үеэр аялал жуулчлалын баазуудын мэдээллийг нийтэд хүргэх зорилгоор мэдээллийн төвийн асрыг ажиллуулсан. - Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо, Монголын аялал жуулчлалын холбоо, Монголын зочид буудлуудын холбоогоор дамжуулан салбарын 600 гаруй | III улирал | 100% |

| | | | | | | | | | |
|---|-----|--|--------------------|---|--|---|--|---------------|-----|
| | | | | | | аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд мэдээлэл түгээх сурталчлах ажлыг зохион байгуулсан. | | | |
| Зорилт 4. Баян-Өлгий, Увс, Ховд, Өвөрхангай, Архангай, Баянхонгор, Өмнөговь, Дорнод, Завхан аймгуудад аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлж, отоглох цэг, авто зам дагуу үйлчилгээний цогцолборуудыг байгуулна. Говийн бусийн аялал жуулчлалыг хөгжүүлнэ. / ЗГҮАХХАХТ 3.4.6/ | | | | | | | | | |
| 6 | 4.1 | Олон улс, улс хооронд, орон нутгийн авто замын дагуу 200 км тутамд үйлчилгээний цогцолбор, 100 км тутамд амрах талбай байгуулах | Гадаад дотоодын ХО | Зам дагуух үйлчилгээний цогцолборын байршилыг тогтоож, Засгийн газрын хурлаар хэлэлцүүлсэн эсэх | АЦБ бүхий түр буудаллах үйлчилгээний цогцолбор байгуулах тэр хувийн хэвшлийн түншлэлийн харилцааг эхлүүлсэн. | Зам дагуух үйлчилгээний цогцолборын байршилыг тогтоож, Засгийн газрын хурлаар хэлэлцүүлсэн эсэх | "Монголд зочлох жил"-ийн хүрээнд "Аялал жуулчлалын гол чиглэлийн авто зам дагуух үйлчилгээний цогцолбор барих газрыг жагсаалтаар батлах тухай" Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, тогтоолын төслийг хуульд нийцүүлэн боловсруулж 2024 оны 05 сарын 01-ний өдрийн 189 дугаар тогтооолоор 58 байршилыг батлуулсан. | III-IV улирал | 90% |
| 7 | 4.2 | Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг/Улсын хэмжээнд/ | 2,325,0 | Шинээр байгуулсан отоглох цэгийн тоо | Нийиспэлийн БЗД, Их тэнгэрийн амны 1 байршилд отоглох цэг барьж байгуулсан. | Орон нутгатай хамтран 6 байршилд отоглох цэг байгуулсан байна. | <p>Байгаль, түүх, соёлын өв бүхий жуулчдын зорин очих газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг байгуулах газрын байршилыг аймаг орон нутгаас санал авч тодорхойлсон.</p> <p>Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд 9 байршилд отоглох цэг байгуулахаар төлөвлөн Терийн нарийн бичгийн даргын 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/168 дугаар тушаалаар Үнэлгээний хороо байгуулан нээлттэй худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Говь-Алтай аймгийн Хөх морьт сумын нутагт отоглох цэг байгуулахаар "Хос гандирс" ХХК - Завхан аймгийн Тэлмэн сумын нутагт отоглох цэг байгуулахаар "Өндөр говь" ХХК - Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын нутагт отоглох цэг байгуулахаар "Нутгийн баруун мод" ХХК - Булган аймгийн Рашаант сумын нутагт отоглох цэг байгуулахаар "Дүүрэн цацал" ХХК шалгарч гэрээ байгуулах зөвлөмж ирсэн. <p>Үүнээс Хэнтий аймгийн Өмнөдэлгэр суманд отоглох цэг байгуулахаар шалгарсан "Нутгийн баруун мод" ХХК нь гэрээ байгуулахаас татгалзсан. Өвөрхангай аймгийн Хужирт сум, Булган аймгийн Баян агт сумын нутагт отоглох цэг байгуулах ажил дээр үнийн санал ирээгүй.</p> | III-IV улирал | 90% |

Зорилго 5. Хил орчмын аялал жуулчлалыг дэмжиж, жуулчдын тоог нэмэгдүүлнэ. /ЗГҮАХХАХТ 3.4.7/

| | | | | | | | | | |
|----|-----|---|-----------|------------------------------------|--|--|--|---------------|------|
| | | | | | | | | | |
| 8 | 5.1 | Хил орчмын аялал жуулчлалын зохицуулах журам батлуулж, хэрэгжилтийг хангах | 100,0 АЖХ | Журам батлагдсан эсэх | Хил орчмын аялал жуулчлалыг зохицуулах журмын төсөл боловсруулсан. | Журмын төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан байна. | <p>Хил орчмын нутаг дэвсгэрийн аялал жуулчлалын үйл ажиллагааг зохион байгуулах, аюулгүй байдлыг хангах журмыг Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 142 дугаар тогтоолоор батлуулсан.</p> <p>Журмын хэрэгжилтийг хангах зорилгоор:</p> <ul style="list-style-type: none"> - Хил орчмын аялагчдын ахлагч, хөтчид олгох нэг жилийн хүчинтэй хугацаатай "орох-гарах" үнэмлэхний загвар, бүлэг жуулчдын 3 сарын хүчинтэй хугацаатай "орох гарах" үнэмлэхний загварыг хятадын талтай зөвшилцэн баталгаажуулсан. - Бүлэг жуулчдын тооны хязгаарыг хил орчмын аялагчдын тоо, Монгол Улс, БНХАУ-ын хэлэлцээр зэргийг үндэслэн 8 ба түүнээс дээш байхаар тодорхойлсон. - Бүлэг жуулчдын нэвтрэх жагсаалтын хятадын талаас ирүүлсэн төсөлд саналаа ХЗДХЯ, ГХЯ-нд хүргүүлсэн. - Монголын талаас хил орчмын аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх хятадын зах зээл дээр ажиллах тур операторуудын жагсаалтыг гаргаж 50 гаруй ААНБ-ыг бүртгэсэн. - Хил орчмын аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах хил хязгаарыг тодорхойлж, аяллын маршрутыг зураглан ХЗДХ-ийн сайдтай хамтран батлахаар хүргүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангаад байна. | III-IV улирал | 100% |
| 9 | 5.2 | Хил орчмын аялал жуулчлалын маршрутыг батлуулж, хэрэгжилтийг хангах | 100,0 АЖХ | Маршрут батлагдсан эсэх | Хил орчмын аялал жуулчлалын маршрутын төсөл боловсруулсан. | Маршрутын төслийг хэлэлцүүлж, батлуулсан байна. | <p>Хил орчмын аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах хил хязгаарыг тодорхойлж, аяллын маршрутыг сумдын нутаг дэвгэрээр, аймгийн нутаг дэвсгэрээр, аймаг дамнасан байдлаар зураглан баталж, Хууль зүй дотоод хэргийн сайдад 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 01/1456 дугаартай бичгээр, 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдөр 01/2699 дугаартай албан бичгээр, 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 01/1066 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.</p> | III-IV улирал | 90% |
| 10 | 5.3 | "Цайны зам" хил дамнасан аялал жуулчлалын төсөл хэрэгжүүлэх, Монгол, Орос, Хятад турван улсын аялал жуулчлалын сайд | 10,0 | Сайд нарын уулзалтад оролцсон эсэх | Гурван улсын аялал жуулчлалын сайд нарын VII хуралд оролцсон. | Гурван улсын аялал жуулчлалын сайд нарын VIII хуралд оролцсон байна. | <p>ОХУ, БНХАУ, Монгол турван улсын аялал жуулчлалын сайд нарын VIII хуралдаан ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын Улаан-Үд хотноо 2024 оны 10 дугаар сарын 29-30-ны өдрийд зохион байгуулагдсан.</p> <p>Тус уулзалтад Оросын талаас Эдийн засаг хөгжлийн яамны дэд сайд , БНХАУ-ын Соёл, аялал жуулчлалын яамны дэд сайд, Монгол Улсын Соёл, спорт, аялал жуулчлал, заруучуудын яамны Төрийн</p> | III-IV улирал | 100% |

| | | | | | | | | | |
|----|-----|--|--------------|-----------------------------|---|--|---|---------------|------|
| | | нарын уулзалтад оролцох | | | нарийн бичгийн дарга А.Даваажаргал нар оролцож гурван улсын аялал жуулчлалын өнөөгийн байдал, хил орчмын аялал жуулчлал, "Цайны зам"-ын аяллын асуудлаар хэлэлцэж протоколд гарын үсэг зурсан. Монголын талаас төлөөлж ТНБД А.Даваажаргал гурван улсын "Цайны зам"-ын аяллын маршрутыг баталж, хэрэгжүүлэх 3 улсын холбогдох яамдын хамтарсан ажлын хэсэг байгуулах, тус ажлын хэсгийг өөрийн биеэр ахалж ажиллах, маршрутын дагуу "Тэмээн жин"-гийн аялал зохион байгуулах ажлыг санаачлан хэрэгжүүлэх саналыг тавьсан. | | | | |
| 11 | 5.4 | Хил дамнасан аялал жуулчлалын төсөл хэрэгжүүлж, "Цайны зам" "Торгоны зам"-ын брэнд аяллыг бий болгох | 100,0 АЖХ | Брэнд аялал бий болсон эсэх | Цайны замын судалгаа хийгдсэн. | "Цайны зам", "Торгоны зам"-ын брэнд аялал бий болж, аялал зохион байгуулагдсан эхэлсэн байна. Хил дамнасан аялал жуулчлал, Цайны замын аялал жуулчлалыг идэвхжүүлэх, хөгжүүлэх зорилгоор ОХУ, БНХАУ-тай хамтран ажиллах саналуудыг солилцон ажиллаж байна. Монгол, ОХУ, БНХАУ гурван улсын холбогдох яамдын хамтарсан ажлын хэсэг байгуулж, "Цайны их зам"-ын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээ болон "Цайны их зам"-ын маршрутыг тодорхойлж, түүнийг дагасан бүтээн байгуулалт, дэд бүтэц, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох зэрэг асуудлуудыг хэлэлцсэн. ССАЖЗЯ-ны зүгээс Цайны замын аяллын маршрутыг бий болгох батлуулах, хөрш оруундтай хамтран ажиллах дотоодын ажлын хэсгийг байгуулаад байна. Цайн их замын аяллын замналын зураглалыг тодорхойлж түүнд түшиглэсэн бүтээгдэхүүнийг бий болгох ажлыг эхлүүлээд байна. Монгол, Орос, Хятад гурван улсын "Цайны зам"-ын аялал жуулчлалыг хөгжүүлэх ажлыг идэвхжүүлэх үүднээс "Цайны замын маршрут"-ыг гарган баталгаажуулж, үйл ажиллагааг эхлүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг 8 судлаачдын бүрэлдэхүүнтэйгээр 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр батлуулаад байна. | III-IV улирал | 100% | |
| 12 | 5.5 | Цайны зам авто ралли /Хятад- | 100.0 | Арга хэмжээг зохион | - | Арга хэмжээг зохион | Засгийн гаэрын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны 15 дугаар тэмдэглэлээр "Торгоны | III-IV улирал | 100% |

| | | | | | | | | |
|--|--|--|--|--------------------|--|----------------------|---|--|
| | | Монгол-Орос/ зохион байгуулах МУТЖУЧ – 8.2.1, ССАЖЗЯГТ – 2.6.11 | | байгуулсан эсэх | | байгуулсан байна. | <p>"зам" олон улсын авто ралли арга хэмжээний бэлтгэл хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулах үүрэг өгөгдэж, Ерөнхий сайдын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 73 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдсан.</p> <p>"Цайны зам", "Торгоны зам"-ын хүрээнд Торгоны зам авто ралли уралдааныг ОХУ-тай хамтран 2024 оны 07 дугаар сард зохион байгуулсан. Тус ажлын хүрээнд Сайдын 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн A/164 дугаартай тушаалаар дэд ажлын хэсэг байгуулан ажиллаа.</p> <p>Монгол улсын нутаг дэвсгэрийг дамнан хоёр дахь удаагаа зохион байгуулагдаж буй 2024 оны уралдааны маршрут нь ОХУ-ын Томск хотоос эхэлж Баян-Өлгий аймгийн Цагааннуур боомтоор нэвтрэн Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Дундговь аймгийн газар нутгийг дайран Улаанбаатар хотод дууссан. Нийт 5500 орчим км замыг түүлж 278 тээврийн хэрэгсэл, оролцогч сонирхогч 752 хүн Монголд ирсэн ба уралдаанд 30 орны 111 тээврийн хэрэгсэл уралдсан болно.</p> <p>Цайны замын аяллын тус авторалли нь Монгол Улсын нутагт уралдахад Монгол Улсаас санхүүгийн дэмжлэг үзүүлэх байдлаар зардал гардаг байсан бол энэ удаа дайран өнгөрч буй орон нутаг, холбогдох салбаруудад мөнгө төлдөг системтэйгээр зохион байгуулагдсанаараа онцлогтой болсон.</p> | |
|--|--|--|--|--------------------|--|----------------------|---|--|

Зорилт 6. "Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд аялал жуулчлалын салбарт технологийн дэвшил нэвтрүүлж, гадаад сурталчилгааг өргөжүүлнэ.
/ЗГУАХХАХТ 3.4.8/

| | | | | | | | | |
|----|-----|---|-------|----------------------------|--|---|------------------|-----|
| 13 | 6.1 | Аялал жуулчлалын цахим орчинд Монгол орныг сурталчилсан платформын мэдээллийг шинэчлэх, контентуудын тоо нэмэгдүүлэх ЗГУАХ 1.3.6.15, ССАЖЗЯГТ – 2.6.10 | 500.0 | Цахим хандалтын хувь | mongoliatravel.guide цахим платформд шинэ мэдээллийг боловсруулан баяжуулж, цахим сурталчилгааг идэвхжүүлж, хандалтын тоог 20-оос доошгүй хувиар нэмэгдүүлсэн байна. | <p>Монгол УИХ-ын чуулганы 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн хурлаар "Засгийн газрын бүрэлдэхүүн"-ийг шинэчлэн тогтоож, ЗГ-ын 2024 оны 06 дугаар тогтоолоор баталсан "Зарим яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар"-ын дагуу аялал жуулчлалын салбарын чиг үүрэг Соёлын яаманд шилжик ирсэн.</p> <p>Байгаль орчин аялал жуулчлалын яамны /хуучин нэрээр/ www.mongoliatravel.guide вэб сайт болон аппликэйшины хамт "Ворлд Плас" ХХК хийсэн боловч 2023 оны 08 дугаар сарын 08-ны цаашид систем дээр хөгжүүлэлт хийж, хариуцан авх явах боломжгүй болсон. Цаашид энэхүү системийн арчлал үйлчилгээ, хэвийн найдвартай байдлыг ССАЖЗЯ хариуцан ажиллах шаардлагага гарсан тул Монголын цахим аялал жуулчлалын холбоо ТББ-аас тухайн системийг хүлээж авах ажлыг зохион байгуулсан.</p> | III-IV улирал | 90% |
|----|-----|---|-------|----------------------------|--|---|------------------|-----|

| Зорилт 7. Аялал жуулчлалын сургалтын төв байгуулж, салбарын чадварлаг хүний нөөцийг бурдүүлнэ. /ЗГҮАХХАХТ 3.4.8/ | | | | | | | | | |
|--|-----|--|---|---|---|---|--|------------------|-----|
| 14 | 7.1 | Аялал жуулчлалын мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвийн барилгыг ашиглалтад оруулах ССАЖЗЯГТ 2.9.11/ | Барилгыг ашиглалтад оруулсан эсэх | Барилгын гүйцэтгэл 90 хувь | Барилгыг ашиглалтад оруулсан байна. | <p>БНСУ-ын буцалтгүй тусламжаар баригдаж байгаа Аялал жуулчлалын сургалтын төвийн барилгын ажлыг дуусгахтай холбоотойгоор:</p> <ul style="list-style-type: none"> - Барилгын явцтай танилцан ажлын гүйцэтгэлтэй холбоотой сайжруулах ажлын саналыг хүргүүлж шийдвэрлүүлж ажилласан. Тухайлбал гадна шилэн хаалгыг солих, 2 давхрын цонхны чанарыг сайжруулах, хурлын танхимд аваарын хаалга гаргах, гарааш дахь цахилгааны утсыг усны хоолойн доод талд байрлуулсан зэргийг өөрчлүүлсэн. - Монголын талаас хэрэгжүүлж буй гадна шугам сүлжээ, цахилгаан, дулаан, бохир, цэвэр усны холболт хийх асуудлыг гүйцэтгэгч байгууллагад хяналт тавьж ажиллаж Улсын комисс ажиллах бэлтгэл ажлыг хангаж ажилласан. - Барилгын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ССАЖЗЯ-ны удирдлагуудын хамт 2-3 удаа очиж ажилласан. - КТО-өөс нэмэлтээр авах бараа материалын жагсаалт гарган хүргүүлсэн. - Гааль болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлэх ажлыг цахимаар хийж Odamis.mof.gov.mn сайтад албан татвараас чөлөөлүүлэх барааны дэлгэрэнгүй жагсаалт болон холбогдох гэрээ, материалыг оруулсан. - 12 дугаар сарын 04-ний өдөр БНСУ-ын АЖТӨК-ийн КТО Улаанбаатар төлөөлөгчийн газрын төлөөлүүдтэй уулзалт хийн барилга байгууламжийг хүлээндүүснээ тухай баримт дээр дээр гарын үсэг зуран хүлээн авсан. | III-IV улирал | 100% | |
| 15 | 7.2 | Аялал жуулчлалын сургалтын төвийн үйл ажиллагааны менежментийн төлөвлөгөөг | 100,0 АЖХ | Менежментийн төлөвлөгөө батлагдаж, үйл ажиллагаа явагдаж эхэлсэн эсэх | Сургалтын төвийн менежментийн төлөвлөгөөний төслийг КТО-оос | Хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулах сургалтын төвийн | <p>Аялал жуулчлалын сургалтын төвийн үйл ажиллагааны менежментийн төлөвлөгөөг боловсруулахаар 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/27 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулан ажилласан.</p> <p>Ажлын хэсэг эхний байдлаар Аялал жуулчлалын сургалтын төвийг цаашид мэргэжлийн боловсролын</p> | III-IV улирал | 90% |

| | | | | | | | | | |
|--|--|---------------------------|--|--|---------------------------|--|--|--|--|
| | | боловсруулж, батлуулах | | | боловсруулан ирүүлсэн. | менежментийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулан төлөвлөгөөний дагуу сургалтын төвийн үйл ажиллагааг эхлүүлсэн байна. | сургуулийн статустайгаар ажиллах боломж, нөхцөл байдлын судалгааг хийж гүйцэтгэсэн. | | |
|--|--|---------------------------|--|--|---------------------------|--|--|--|--|

ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Зорилт 8. Аялал жуулчлалын талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавих

| | | | | | | | | | |
|----|-----|---|------|---|---|---|--|---------------|-----|
| 16 | 8.1 | Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тусгасан зорилго, зорилтын салбарт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангах МУЗГТХ-30.1, БХУЗТХ-12.1.2, МУЗГ-2023 оны 481 тогтоол, ССАЖЗЯГТ 1.1.9 | - | Арга хэмжээний хэрэгжилт хангагдсан эсэх | Үзэл баримтлалд тусгагдсан аялал жуулчлалын салбарт хэрэгжих төсөл, арга хэмжээний хэрэгжилт хангагдсан байна. | Аялал жуулчлалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт аялал жуулчлалын бүстэй байх заалтын дагуу бус тогтоох ажлыг хийж гүйцэтгэлээ. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан соёлын нөөц, байгалийн аялал жуулчлалын нөөц тэдгээрийг газар зүйн байршилтай уялдуулан орон зайн дүн шинжилгээ хийж, тээвэр дэд бүтэц, логистик, эдийн засгийн коридор бус нутгийн эдийн засгийн интеграци, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот суурин газар зэргийг харгалзан 7 аялал жуулчлалын бүсчлэл, 57 аялал жуулчлалын орон зайлгүүлж тодорхойлоод байна. Цаашид нарийвчилсан үнэлгээ хийж улсын аялал жуулчлалын бүсийг тогтоож, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ажилж байна. | III-IV улирал | 100% | |
| 17 | 8.2 | Улсын болон олон улсын уралдаан, наадам зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх AX-2050 - 1.1.1, 1.1.20, МУХТЖҮЧ - 1.2.3, ССАЖЗЯГТ - 2.3.19 | 50,0 | Уралдаан зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн эсэх | "Бүх дэлхийн Алтаргана-2024" олон улсын 15 дугаар их наадам зохион байгуулахад дэмжлэг үзүүлэхээр тусгагдсан байсан ч Соёлын яамтай нэгдсэнээр төсвийг давхардуулж олгохгүй байх шийдвэрийн дагуу цуцлагдсан. | III-IV улирал | - | | |
| 18 | 8.3 | Түүхэн аялал жуулчлалын үзэл баримтлалыг боловсруулах | - | Үзэл баримтлал боловсруулаг д-сан эсэх | Түүхэн аялал жуулчлалын цогцолборуудын үзэл баримтлал | Үзэл баримтлал боловсруулж, танилцуулсан байна. | Монгол Улсыг Засгийн газраас Зүүн бүсийг түүхэн аялал жуулчлалын бус болгон зарласантай холбогдуулан Түүхэн аялал жуулчлалын бүсийн үзэл баримтлалыг боловсруулах ажлыг хэрэгжүүлсэн. Тухайлбал: | III-IV улирал | 90% |

| | | | | | | | | | |
|----|---|---|---|----------------------------|--|--|---|---------------|------|
| | МУТЖУЧ – 8.2.2, ССАЖЗЯГТ – 2.6.1 | | | боловсруулагдсан. | | <ul style="list-style-type: none"> - Их Эзэн Чингис хааны түүхэн газрууд, дурсгал бүхий Хэнтий аймагт их хааны түүхтэй холбоотой баригдаж байгаа аялал жуулчлалын цогцолборуудын үзэл баримтлалд тулгуурлан цогц үзэл баримтлалыг боловсруулах - Улсын аялал жуулчлалын бус тогтоохтой уялдуулан эүүн бүсийг дан ганц Чингис хааны түүх бус Дэлхийн II дайнтай холбоотой түүхийг өгүүлэх бус - Монгол Улсын тусгаар тогтолцын төлөө тэмцэж байсан шилийн сайн эрсийн түүх - Орчин үеийн хөгжлийн түүх гэсэн чиглэлүүдээр хөгжүүлэх боломжуудыг судалж байна. <p>Их Эзэн Чингис хааны түүхийг илэрхийлэх, түүхэн аялал жуулчлалын маршрутыг бий болгох зорилтын хүрээнд Чингис хааны өв соёлын хүрээлэнтэй хамтран ажиллахаар тохиролцож 2024 оны 12 дугаар сарын 12-нд “Түүх, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж” буюу Чингис хаан: XXI зууны энтертаймэнт орчинд хэлэлцүүлгийг хамтран зохион байгууллаа.</p> | | | |
| 19 | 8.4 | Буйр нуурын усан боомтыг түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөөний төсөл боловсруулж, батлуулах ЗГҮАХ 1.3.6.1, ССАЖЗЯГТ – 2.6.2 | - | Төлөвлөгөө батлагдсан эсэх | Дорнод аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөө | Төлөвлөгөө батлагдсан байна. | <p>Шинэ Засгийн газрын 100 хоногт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Буйр нуурын усан боомтыг түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилт тусгагдсан. Тус зорилтын хэрэгжилтийг хангах зорилгоор дараах арга хэмжээг хэрэгжүүлээд байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Орон нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө, хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг судлах - Улсын аялал жуулчлалын бус тогтоох шалгуур үзүүлэлтийн дагуу Буйр нуур орчмын нөхцөл, байдал, нөөцийг тодорхойлох - Буйр нуур ормын газар нутгийн өнөөгийн байдал, тус нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн газрын асуудлыг тодорхойлох - Буйр нуурын усан боомтыг түшиглэсэн аялал жуулчлалын бүсийг улсын тусгай хэрэгцээнд авах асуудлыг судалж, танилцуулах үүрэг бүхий хамтарсан ажлын хэсгийг байгуулах - Бүсчилсэн хөгжлийг дэмжих бүтээн байгуулалтын төслийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах ажлын даалгаврыг боловсруулан батлуулж, зөвлөх | III-IV улирал | 100% |

| | | | | | | | | | |
|----|-----|---|---|---|---|---|---|---------------|------|
| | | | | | | үйлчилгээний худалдан авах ажиллагааг зарлуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгээд байна. | | | |
| 20 | 8.5 | Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрийг зүүн бусийн "Түүхэн аялал жуулчлалын бүс" болгох менежментийн төлөвлөгөө боловсруулж, батлуулах МУТЖҮЧ – 8.2.2, ССАЖЗЯГТ – 2.6.3 | - | Менежментийн төлөвлөгөө батлагдсан эсэх | Засгийн газрын 2024 оны "Зүүн бусийг "Түүхэн аялал жуулчлалын бүс" болгон зарлах тухай" 174 тогтоол | Менежментийн төлөвлөгөө батлагдсан байна. | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдөр хуралдаанаар Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрийг зүүн бусийн түүхэн аялал жуулчлалын бүс болгох менежментийн төлөвлөгөөг хэлэлцүүлж, "Түүхэн аялал жуулчлалын бүсийг хөгжүүлэх төлөвлөгөө батлах тухай" 239 дугаар тогтоолыг батлуулсан. | III-IV улирал | 100% |
| 21 | 8.6 | Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх менежментийн төлөвлөгөө боловсруулж, батлуулах ЗГҮАХ 1.3.6.1, ССАЖЗЯГТ – 2.6.4 | - | Менежментийн төлөвлөгөө батлагдсан эсэх | Засгийн газрын 2024 оны 142 дугаар тогтоол "Хил орчмын нутаг дэвсгэрийн аялал жуулчлалын үйл ажиллагааг зохион байгуулах, аюулгүй байдлыг хангах журам" | Менежментийн төлөвлөгөө батлагдсан байна. | Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор: - Хил орчмын болон "Цайны зам"-ын маршрутын дагуу автомашинтай аялах хүсэлтэй жуулчдад түр дугаар, жолоочид түр үнэмлэх олгох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх - Гадаадын жуулчдын худалдан авсан бүтээгдэхүүний НӨАТ-ын буцаан олголтыг үнийн дүнгээс үл хамааран олгох, татварын буцаан олголтын техник хэрэгслийг Замын-Үүд, Алтанбулаг, Боршоо, Ханх, Эрээнцав, Хавиргын боомтод байршуулах - Монгол Улсад хилийн боомтоор жил бүрийн 11 дүгээр сарын 01-нээс дараа жилийн 05 дугаар сарын 01-ний хооронд орж ирэх жуулчдад тухайн хилийн боомт дээр богино хугацаанд виз олгох, бүлэг жуулчныг нэвтрүүлэх тусгай гарц бий болгох - Хил орчмын аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэрийн хамрах хүрээ, аяллын маршрутыг тодорхойлж, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талтай дипломат шугамаар тохиролцох - Хил орчмын аялал жуулчлалыг дэмжих, жуулчдын ургалыг татах, эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх зорилгоор бараа бүтээгдэхүүнд 50 хувь хүртэлх үнийн хөнгөлөлт бүхий "Happy Januagy" буюу "Хямдралын сар" аяныг тогтмол зохион байгуулж хэвшүүлэх зэрэг арга | III-IV улирал | 100% |

| | | | | | | | | |
|----|---|-----------|---|---|---|--|---------------|------|
| | нэгдсэн төлөвлөгөө боловсруулж, батлуулах ЗГУАХ 3.3.5.1, ЗГ-ын 2023 оны 458 дгаар тогтоол, ССАЖЗЯГТ - 2.6.8 | | | | | байгууллагатай хамтран ажиллах хүрээнд Монгол Улсын аялал жуулчлалын хөгжлийн стратеги боловсруулах ажлыг Бостон Консалтинг Групптэй хамтран ажиллаж байна. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.5-д Дөрвөн улирлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилт тавьж, ялангуяа өвлийн улирал, 10 сараас дараа оны 5 сар хүртэлх хугацаанд жуулчдын ургалыг татах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж байна. Энэ хүрээнд: - Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг - Жуулчдын ургалыг татах ажлын хэсэг - Эвент арга хэмжээний цагалбар гаргах ажлын хэсгүүдийг байгуулсан ажилласан. | | |
| 27 | 8.12 Тусгай сонирхлын аялал жуулчлалын үйл ажиллагааг зохицуулах журмыг батлуулах | - | Журам батлагдсан эсэх | Аялал жуулчлалын тухай хууль шинэчлэгдэн батлагдсан. | Журмын төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан байна. | Мөн эхний байдлаар Засгийн газрын хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцүүлээд байна. Өвлийн улиралд ажиллах жуулчны бааз, амралтын газрын тоо, хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор цахилгааны шөнийн тарифын хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж нийт 55 байгууллага хамрагдан 360 гаруй сая төгрөгийн урамшуулалт олгогдсон. | | |
| 28 | 8.13 Дотоодын аялагчдын ургалыг нэмэгдүүлэх, байгальд ээлтэй | 100,0 АЖХ | Нэлөөллийн аяныг зохион байгуулсан эсэх | "Ирлээ, явлаа, цэвэр", Монголд зочлох жил-2023 аянуудыг | "Монгол зочлох жил-2024" болон "Go Mongolia", байгальд | Аялал жуулчлалын тухай хуулийн 21 дүгээр эйлийн 21.1.12 дахь хэсэгт заасны дагуу Тусгай сонирхлын аялал жуулчлалын үйл ажиллагааг зохицуулах журмын төслийг боловсруулан БОАЖ-ын сайдын 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/18 дугаар тушаалаар батлуулаад байна. Журмын хэрэгжилтийг хангуулах ажлыг эхлүүлж орон нутагт хийгдэж буй сургалтуудад аялал жуулчлалын эрх зүйн орчны шинэчлэлийн асуудлуудыг танилцуулахаас гадна Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо, Монголын зочид буудлуудын холбоо, Монголын аялал жуулчлалын холбоо, Монголын хөтөч тайлбарлагчдын нэгдсэн холбоо зэрэг холбогдох төрийн бус байгууллагуудад албан бичгээр хамтран ажиллах саналыг батлагдсан журмын хамт хургуулээд байгаа болно. | III-IV улирал | 100% |

| | | | | | | | | | |
|----|------|--|---|---|--|--|---|---------------|------|
| | | зүй зохистой аялах, аяллын боловсролыг нэмэгдүүлэх аяныг зохион байгуулсан байна. | | зохион байгуулсан. | зэлтэй аялах нөлөөллийн аянуудыг зохион байгуулсан байна. | уриан дор зохион байгуулах шийдвэр Засгийн газраас гарсан. - "Go Mongolia" сурталчилгааны цогц арга хэмжээг хэрэгжүүлэх дотоодын аялагч жуулчид болон Монгол Улсад ирж буй гадаадын жуулчдыг нисэх буудалд буухаас нь эхлэн уган авах сурталчилгааны самбаруудыг шинэчлэн байршууллаа. Тус арга хэмжээний хүрээнд $1,09*1,54$ м хэмжээ бүхий сурталчилгааны хэвлэмэл контентийг бий болгож Улаанбаатар хотын хэмжээнд 6 дүүргийн 180 байршил самбарын мэдээллийг сольж байршуулсан. - ХХЕГ-тай хамтран хилийн 10 боомтын мэдээллийн хэсэгт "Go Mongolia"-ийн сурталчилгааны контентуудыг цацаж эхэлсэн. - Засгийн газрын хуралдаанаас "Go Mongolia" брэндийг Монгол Улсыг сурталчлах зорилгоор төр, хувийн хэвшлийн бүх байгууллага ашиглах боломжийг бүрдүүлсэн. | | | |
| 29 | 8.14 | "Эко аялал жуулчлалын гэрчилгээжүүлэлт" хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг боловсруулж, батлуулах | - | Эко аялал жуулчлалын гэрчилгээ олгосон эсэх | "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл 1"-ийн хүрээнд "Эко аялал жуулчлалын гэрчилгээжүүлэлт"-ийн хөтөлбөрт 5 жуулчны баазыг хамруулсан. | - Эко гэрчилгээжүүлэлтийн хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг батлуулсан. - Эко гэрчилгээжүүлэлтийн хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн дагуу жуулчны баазуудыг үнэлэх арга хэмжээг зохион байгуулна. | Эко аялал жуулчлалын үндсэн 7, дэд 24 шалгуур үзүүлэлтийг боловсруулсан. Шалгуур үзүүлэлтийн дагуу эхний жуулчны баазуудын үнэлгээг хийгээд байна. Үнд: - Хөвсгөл Трэйвэл ХХК-ны "Тойлогт" жуулчны бааз - Байгаль-Үүд ХХК-ны Байгаль-Үүд жуулчны бааз - Өсөх Өнөр ХХК-ийн "Леона Ресорт" жуулчны бааз - Хөвсгөл Баян -Улаан ХХК-ийн "Баян -Улаан" жуулчны бааз - Дангина Хатан ХХК-ийн "Дангина Хатан" жуулчны баазуудыг нээлттэй сонгон шалгаруулалтад орсон. | III-IV улирал | 100% |

| | | | | | | | | | |
|----|-----|--|--------------|--|---|---|---|---------------|------|
| 30 | 9.1 | Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах АХ 2050 - 1.4, "СБУДАХ"- 8.1.1, ССАЖЗЯГТ 1.1.17 | 15,0 АЖХ3 | Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулагдаа н эсэх | Аялал жуулчлал судлал-2023 ЭШХ зохион байгуулсан. | "Аялал жуулчлал судлал-2024" эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан байна. | "Аялал жуулчлал судлал-2024" эрдэм шинжилгээний хурал аялал жуулчлалын салбарт хийгдсэн судалгаа, шинжилгээний явц, үр дүнг олон нийтэд таниулах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Чингис хаан Үндэсний музейд зохион байгуулагдсан. Тус арга хэмжээнд нэгжийн дарга салбарын бодлого, арга хэмжээний талаар танилцуулж, мөн 5 хэсэг бүхий хуралдаанд аялал жуулчлалын хөгжлийн чиг хандлага, соёл ба аялал жуулчлал, аялал жуулчлалын зах зээл, хөгжлийн инновац, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, аялал жуулчлал ба үйлчилгээ зэрэг сэдвийн хүрээнд салбарын багш, эрдэмтэн судлаач, танилцуулж хөлөлцүүлсэн. Хуралд төр, хувийн хэвшил, салбарын эрдэмтэн судлаачдын төлөөлөл оролцлоо. Мөн тухайн арга хэмжээнд тусгагдсан санхүүжилтыг шийдвэрлүүлэхээр холбогдох баримт бичгийг боловсруулан, хянуулсан боловч зардал шийдвэрлэгдээгүй болно. | III-IV улирал | 100% |
| 31 | 9.2 | Аялал жуулчлалын их, дээд сургуулиудын оюутнуудын дунд "Гранд тур" эрдэм шинжилгээний бага хурал, олимпиадыг зохион байгуулах /ССАЖЗЯГТ 2.6.7/ | 15,0 | Аялал жуулчлалын улсын олимпиад, Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан эсэх | Жил бүр "Гранд тур" олимпиад, эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулсан. | "Гранд тур" олимпиад, "Аялал жуулчлал судлал-2024" эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, 100-иас доошгүй залуучууд, оюутныг хамруулсан байна | Дэлхийн аялал жуулчлалын өдөрт зориулан "Grand Tour" аялал жуулчлалын улсын олимпиад зохион байгуулагдаар ирсэн бөгөөд энэ жилийн 22 дахь удаагийн олимпиадыг Монгол оронд аялал жуулчлалын салбар үүсэж хөгжсөний түүхт 70 жилийн ой болон Дэлхийн аялал жуулчлалын өдрийн хүрээнд 2024 оны 04 сарын 26-28 өдрүүдэд болон 2024 оны 09 сарын 20-27-ны өдруүдэд амжилттай зохион байгуулсан. "Grand Tour 2024" аялал жуулчлалын улсын олимпиадад нийт 18 сургуулийн 35 багш 500 оюутан оролцсон. | III-IV улирал | 100% |
| 32 | 9.3 | Үндэсний хэмжээнд байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр сургалт зохион байгуулах | 500,0 АЖХ | Улсын хэмжээнд бодлого, эрх зүй, зочлох үйлчилгээний сургалт, сурталчилгаа хийгдсэн эсэх | 21 аймгийн БОАЖГ-ын удирдлага, мэргэжилтнүүд ийг хамарсан сургалт, уулзалт зохин байгуулагдсан. | Байгаль орчныг хамгаалах, аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого, эрх зүй, зочлох үйлчилгээний сургалт, сурталчилгаа орон нутагт | Аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарын өөрчлөлт, шинэчлэлтийн талаар үндэсний хэмжээнд нэгдсэн ойлголтод хүрэх, хамтран ажиллах зорилтыг хэрэгжүүлэхээр: - Хөвсгөл аймгийн Мөрөн хотод "Аялал жуулчлалын хөгжилд нутгийн иргэдийн оролцоо" зөвлөгөөнийг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулж 400 гаруй хүн оролцсон. - Хэнтий аймгийн Чингис хотод "Аялал жуулчлалын хөгжилд орон нутгийн иргэдийн оролцоо" сургалт, зөвлөгөөнийг 2024 оны 05 дугаар сарын 9-ний өдөр төр, | III-IV улирал | 100% |

| | | | | | | | | |
|--|--|--|--|--|-----------------|---|--|--|
| | | | | | хийгдсэн байна. | <p>хувийн хэвшил, иргэдийн оролцоо бүхий 300 гаруй оролцогчтойгоор зохион байгуулсан.</p> <ul style="list-style-type: none"> - Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотод "Аялал жуулчлалын хөгжилд нутгийн иргэдийн оролцоо" зөвлөгөөнийг 2024 оны 05 дугаар сарын 11-ний өдөр 250 гаруй оролцогчтойгоор - Завхан аймгийн Улиастай хотод "Аялал жуулчлалын хөгжилд орон нутгийн иргэдийн оролцоо" сургалт, зөвлөгөөнийг 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдөр тус тус зохион байгуулсан. <p>Аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарын оролцогч талууд, багш судлаачдын мэргэжлийн чадавхыг нэмэгдүүлэх, олон улсын туршлага хуримтлуулах, орчин үеийн инновацын шилдэг шийдлийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор БНСУ-аас зочин багш урин 2024 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр "Аялал жуулчлал, зочлох үйлчилгээний инновац, төгөлдөршил" сэдэвт сургалт, семинарыг "Аялал жуулчлалын боловсрол ба хүний нөөцийн асуудал", "Аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарын инновац ба манлайлал", "Аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарын шинэлэг шийдэл", "Аялал жуулчлалын сургалт ба чанарын баталгаажилт" гэх агуулгын хүрээнд зохион байгуулсан.</p> <p>Тус сургалт, семинарт аялал жуулчлалын салбарын багш, судлаач, аялал жуулчлал ба зочлох үйлчилгээний салбарын нийт 56 хүнийг хамруулан гэрчилгээ олгосон.</p> | | |
|--|--|--|--|--|-----------------|---|--|--|

Зорилт 10. Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр улсын болон олон улсын хэмжээнд аялал жуулчлалын байгууллага хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хамтран ажиллах

| | | | | | | | | | |
|----|------|---|-----------|---|--|---|---|---------------|------|
| 33 | 10.1 | Олон улсын туршлага судлах, хүний нөөцийг чадавхжуулах фам тур зохион байгуулах | 30,0 АЖХ | Салбарын мэргэжилтнүү дийг фам турт хамруулсан эсэх | БНСУ-д туршлага судлах аялалд оролцуулсан. | Салбарын 5 хүртэлх мэргэжилтнүүд ийг фам турт хамруулсан байна. | <p>Монголд зочлох жилийн хүрээнд зочлох үйлчилгээний байгууллагуудын үйлчилгээний чанар стандартыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, жуулчдыг ая тухтай амрах нэхцэлийг хангах зорилгоор Бүгд Найрамдах Солонгос Улсын зочлох үйлчилгээний стандартын туршлага судлах, үндэсний хэмжээнд нэвтрүүлэх арга хэмжээнд орон нутгийн Хэнтий, Увс аймгийн аялал жуулчлалын мэргэжилтнүүдийг хамруулсан.</p> <p>Тус сургалтыг Монголын зочид буудлуудын холбоотой хамтран зохион байгуулсан.</p> | III-IV улирал | 100% |
| 34 | 10.2 | Дэлхийн аялал жуулчлалын байгууллагатай хамтын | 250,0 АЖХ | Хамтын ажиллагааг өргөжүүлсэн эсэх | 2023 оны гишүүнчлэлийн зардлыг шилжүүлсэн. | -Өмнөх онуудын гишүүнчлэлийн өр, төлбөрийг | Монгол Улсын аялал жуулчлалын салбарт Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын гишүүнээр элсэн орж, гишүүнчлэлийн татварыг жил бүр төлж ирсэн. | III-IV улирал | 100% |

| | | | | | | | | | |
|----|------|---|--------------|---|---|---|--|------------------|------|
| | | ажиллагааг өргөжүүлэх | | | барагдуулсан байна. -Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас зохион байгуулагддаг гишүүдийн сургалт, хуралд Монгол Улсыг төлөөлж оролцсон байна. | ДАЖБ-аас ирсэн 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн нэхэмжлэхийн дагуу 2024 оны гишүүнчлэлийн татвар болох 35,925 европийн төлбөрийг төлөх тухай БОАЖЯ-ны ТНБД-ын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/178 дугаартай "Хөрөнгө гаргах тухай" тушаалыг батлуулж, төлбөрийг шилжүүлээд байна. | | | |
| 35 | 10.3 | Дэлхийн аялал жуулчлалын өдрийг утсан салбарын бүтээлч ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх ССАЖЗЯГТ- 2.6.6 | 100.0 | Төлөвлөгөө батлагдаж, хэрэгжилт хангагдсан эсэх | Зохион байгуулдаг арга хэмжээ тогтмолжсон. | Төлөвлөгөө батлагдаж, хэрэгжилт хангагдсан байна. | Дэлхийн аялал жуулчлалын өдрийг утсан салбарын бүтээлч ажлын хүрээнд 21 аймгууд 1-2 арга хэмжээг зохион байгуулах, аялал жуулчлалын салбарын мэргэжлийн холбоо, байгууллагууд тус өдрийг утган зохион байгуулах арга хэмжээний саналыг хүлээн авч нэгтгэсэн. Дэлхийн аялал жуулчлалын өдрийг утсан салбарын бүтээлч ажлын хүрээнд Аялал жуулчлалын салбарын нэгдсэн форум арга хэмжээ 10 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулагдсан. Нийт 1000 орчим аялал жуулчлалын салбарын төр, хувийн хэвшил, эрдэмтэн судлаачид, бизнесийн байгууллагуудын төлөөлөл оролцож, мөн салбарын хэмжээнд төрийн дээд одон медаль, салбарын тэргүүн жуух бичгээр салбартай хувь нэмэр оруулж, үр бүтээлтэй ажиллаж байгаа иргэдийг шагнан урамшууллаа. Тус арга хэмжээнд аялал жуулчлалын салбарын түүх, үйл ажиллагааны үр дүн, салбарын бодлого, хөгжлийн тоймыг танилцууллаа. | III-IV улирал | 100% |
| 36 | 10.4 | Дипломат харилцаа тогтоосны орнуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, хурал, аялал жуулчлалын арга хэмжээ зохион байгуулах, оролцох | 300,0 АЖХ | Арга хэмжээнд оролцсон эсэх | Швейцарь, ХБНГУ, БНХАУ зэрэг орнуудтай хамтран ажиллаж аялал жуулчлалын арга хэмжээ зохион байгуулж, оролцсон байна. | Дипломат харилцаа тогтоосон орнуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, хурал, арга хэмжээг зохион байгуулах, оролцох зорилтын хүрээнд: 1. Швейцарь улсын ФЕСПО олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнгийн үлдэгдэл төлбөрийн асуудлыг шийдвэрлэж хоёр орны хамтын ажиллагааг сэргээх арга хэмжээг зохион байгуулж байна. Үлдэгдэл төлбөрийг шийдвэрлэсэн тушаалыг 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/206 дугаартай батлуулаад байна. 2. ХБНГУ-ын Берлин хотод зохион байгуулагддаг "ITB" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Монголд зочлох жилийн хүрээнд "Go Mongolia" уриан дор 15 тур | III-IV улирал | 100% | |

| | | | | | | | | | |
|----|------|--|-----------|---|---|---|---|---------------|------|
| | | | | | | оператор оролцсон. Уг үзэсгэлэнд оролцох зорилтыг хангахад БОАЖЯ-ны зүгээс дэмжин хамтран ажиллаж, талбайн түрээсийг төлөх шийдвэрийг гаргаж, 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/104 дугаартай ТНБД-ын тушаалаар санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэсэн. | | | |
| 37 | 10.5 | Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагуудыг дэмжих ажиллах /ITM, Hospitality and tourism expo-2024, Хорека, Улаанбаатар, дотоодын аялал жуулчлалын үзэсгэлэнгүүдэд зохион байгуулахад дэмжих ажиллах/ | 100,0 АЖХ | Аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудыг дыг дэмжих ажилласан эсэх | Төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжин ажилласан. | ITM, Hospitality and tourism expo-2024, Хорека, Улаанбаатар трэйвэл, дотоодын аялал жуулчлалын экспог зохион байгуулсан байна. | <p>3. БНХАУ буюу өмнөд хөршид Монгол Улсыг сурталчлах "Go Mongolia" арга хэмжээг Гуан жоу, Хонконг, Бээжин хотуудад зохион байгуулах хүрээнд дараах ажлыг гүйцэтгэн тайлан бэлтгэж ирүүлнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - "Go Mongolia" арга хэмжээг БНХАУ-ын Гуан жоу, Хонконг, Бээжин хотуудад 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрөөс 29-ний өдруүдэд амжилттай зохион байгуулсан. Арга хэмжээний үеэр Монгол гэр барьж уламжлалт зан заншил, идээ ундаа, үндэсний хувцас, үндэсний урлагагаа Хятадын ард түмэнд сурталчлан танилцуулсан. <p>Арга хэмжээний үеэр Монгол Улсаас БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бус болох Хонконгт суугаа Ерөнхий консулын газар, Монгол Улсаас БНХАУ-д суугаа Бээжингийн элчин сайдын яам, Нийслэлийн аялал жуулчлалын газар, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо түүний Хятад зах зээлийн салбар холбоо, Хүннү эйр ХХК хамтран зохион байгуулж 17 тур оператор компани оролцон үйл ажиллагаагаа танилцуулсан.</p> <p>"АйТИЭМ-Монголиа" үзэсгэлэн арга хэмжээг 25 дахь жилдээ "Үндэсний соёл, аялал жуулчлал, технологийн хөгжил"uriатайгаар 2024 оны 10 дугаар сарын 25-27-ны өдруүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулсан.</p> <p>Тус үзэсгэлэн нь бизнес эрхлэгчдийн хооронд холбож, шинэ бизнесийн тунш олох, гэрээ хэлэлцээр хийх, бараа бүтээгдэхүүн сурталчлах, борлуулах зэрэг боломжийг олгодог. Мөн үндэсний технологийн дэвшилийг салбарын хэмжээнд нэвтрүүлэх үүднээс МАЖХ, "Эрксис" аялал жуулчлалын технологийн компанийтай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан. Үзэсгэлэнд 18 аймаг нэгдсэн зохион байгуулалттайгаар, тур оператор, жуулчны бааз, ресторан зоогийн газар, аяллын хэрэгсэл ханган нийлүүлэгч, аяллын бүтээгдэхүүн үйлчилгээ эрхлэгч, урлаг соёлын нийт 200 гаруй аж ахуй нэгж, байгууллага оролцож, 4000 гаруй хүн ирж үзэж сонирхсон.</p> | III-IV улирал | 100% |

Зорилт 11. Аялал жуулчлалын дэд бүтцийг бий болгоход дэмжлэг үзүүлэх

| | | | | | | | | | |
|---|------|--|-------------|---|--|--|--|---------------|------|
| 38 | 11.1 | Аялал жуулчлалыг хөгжүүлэх 55 тэрбумын хөнгөлөлттэй зээлийн хүүгийн татаас | 3,041,1 АЖХ | Хүүгийн татаас төлсөн эсэх | - | Аялал жуулчлалыг хөгжүүлэх хөнгөлөлттэй зээлийн хүүгийн татаас төлсөн байна. | Аялал жуулчлалыг хөгжүүлэх 55 тэрбумын хөнгөлөлттэй зээлийн олголт 12 дугаар сарын байдлаар 14,6 тэрбум төгрөгийн зээл олгож 778,2 сая төгрөг хүүгийн татаасанд өгсөн. | III-IV улирал | 100% |
| Зорилт 12. Монгол орныг гадаад, дотоодод сурталчлах | | | | | | | | | |
